

Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Барааны нэр: Мах

1	Стандарт	MNS1111:2007, MNS2457:2009, MNS5023:2001, CAC/RCP7:1974 стандартын шаардлага хангасан хонь, ямаа, үхрийн мах байна.
2	Шинж чанар	-Улаан ба улаан хүрэн мах, цайвар өөхтэй, -Тухайн махны өөрийн өвөрмөц үнэртэй, чанар байдлаа алдаж муудаагүй, гадны ямар нэгэн үнэргүй, -Цээжний хөндийд дотор эрхтэн болон цусны үлдэгдэлгүй, сэвс, шороо зэрэг гадны бохирдолгүй байна, -РН=5,4-5,8
3	Зэрэглэл	-MNS1111:2007 стандартад заагдсан 1,2 дугаар зэргийн шаардлага хангасан 18 кг-аас доошгүй жинтэй хонины мах байна.
4	Тодорхойлолт	-Хонь, ямаа, үхрийн мах: Цусыг юүлж, толгой шийрийг салгаж, арьсыг өвчин, дэлэн, үржлийн эрхтэн болон цээжний ба хэвлийн хөндийгөөс дотор эрхтэнг салгаж авсны дараа үлдэх арьс яс, булчин эд, гадар өөхөөс бүрдэх гулууз мах. - Өрөөл мах: Хүзүү, сээр, нуруу, өвчүүний дагуу ижил хэмжээтэй таллан хуваасан тураг махыг сээр нурууны 11,12 дугаар үений заагаар, 11,12 дугаар хавирганы дундуур салгаж цээжний хэсэг, гуя сүвээний хэсэг болгон хуваасан мах.
5	Хяналт шалгалт	-Үйлдвэрийн аргаар боловсруусан, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан байна. -Мах нэг бүрчлэн тухайн үйлдвэрийн дугаар бүхий тэмдэг дарсан байна.

6	Хүлээн авах	<p>-Нийлүүлэхээр санал болгож буй бүтээгдэхүүндээ мал эмнэлэг, ариун цэвэр-гарал үүслийн гэрчилгээ.</p> <p>-Эрүүл ахуйн аюулгүй байдлын тухай эрх бүхий лабораторийн шинжилгээ.</p> <p>-Мэргэжлийн хяналтын дүгнэлт тус бүрийн нотариатоор баталгаажуулсан хуулбар хувийг тендерийн материалд хавсаргах.</p> <p>-Холбогдох баримтыг үндэслэн 2 талын комисс, заавар, дүрмийн дагуу нэг бүрчлэн үзлэг шалгалт хийж, хүлээн авна.</p>
7	Хадгалалт тээвэрлэлт	<p>-Зориулалтын хөлдөөх төхөөрөмж бүхий зооринд технологийн дагуу боловсруулалт хийн гүйцэд хөлдөөн хадгалах бөгөөд гүний температур -180С-ээс ихгүй байна.</p> <p>-Хэрэгцээтэй үед тухай бүрт нь авч байна.</p>

Барааны нэр: Дотор махан таташ

1	Стандарт	MNS5023:2001, MNS1111:2007, MNS1804:2006 , стандартын шаардлага хангасан хонь, ямааны дотор мах байна.
2	Шинж чанар	<p>-Тухайн махны өөрийн өвөрмөц үнэртэй, чанар байдлаа алдаж муудсан буюу гадны ямар нэгэн үнэргүй.</p> <p>-Дотор махны дотор цөс, давсаг уйланхай, булчирхай болон цусны үлдэгдэлгүй, сэвс, шороо, зэрэг гадны бохирдолгүй байна.</p> <p>-РН=5.4-5.8</p>
3	Зэрэглэл	MNS1111:2007, MNS1804:2006 стандартад заагдсан дотор мах байна.
4	Тодорхойлолт	<p>Дотор махан бүтээгдэхүүн: Дотор махыг авриз байдлаар бэлтгэн 20 кг хүртэл хэмжээтэй савлаж битүүмжилсэн байх.</p> <p>-MNS CAC 1:2007 стандартыг хангасанбайх.</p>
5	Хяналт шалгалт	<p>-Үйлдвэрийн аргаар боловсруулсан, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан байна.</p> <p>-Дотор махан бүтээгдэхүүн нэг бүрчлэн тухайн үйлдвэрийн дугаар бүхий тэмдэгтэй шошготой байна.</p>

6	Хүлээн авах	<p>-Нийлүүлэхээр санал болгож буй бүтээгдэхүүнээ мал эмнэлэг, ариун цэвэр-гарал үүслийн гэрчилгээ.</p> <p>-Эрүүл ахуйн аюулгүй байдлын тухай эрх бүхий лабораторийн шинжилгээ.</p> <p>-Мэргэжлийн хяналтын дүгнэлт тус бүрийн нотариатороор баталгаажуулсан хуулбар хувийг тендерийн материалд хавсаргах.</p> <p>-Холбогдох баримтыг үндэслэн 2 талын комисс ззавар, дүрмийн дагуу нэг бүрчлэн үзлэг шалгалт хийж, хүлээн авна.</p>
7	Хадгалалт тээвэрлэлт	<p>-Зориулалтын хөлдөөх төхөөрөмж бүхий зооринд технологийн дагуу боловсруулалт хийн гүйцэд хөдөлгөөн хадгалах бөгөөд гүний температур нь -180С-ээс ихгүй байна.</p> <p>-Хэрэгцээтэй үед тухай бүрт нь авч байна.</p>

Барааны нэр: Хүнсний ногоо

№	Техникийн үзүүлэлт тавигдах шаардлага
1	<p>-Гарал үүслийн гэрчилгээтэй байна.</p> <p>-Өнгө үзэмж сайтай байх.</p> <p>-Эрүүл ахуйн шаардлага хангасан байх.</p> <p>-Хүнсний бүтээгдэхүүний стандартад нийцсэн байх.</p> <p>-Тээвэрлэлт, хадгалалт хамгаалалтын стандарт шаардлагыг хангасан байх.</p> <p>-Шаардлагатай бүх шинжилгээнд хамрагдсан байх.</p>

Барааны нэр: Гурил

1	Стандарт	Буудайн гурил. Техникийн ерөнхий шаардлага. MNS 0244:2009
2	Барааны ерөнхий шинж чанар	<p>БГТ-075, БГ-085, БГ-115 ангиллын гурил байх бөгөөд өнгө, үнслэг, ширхэгжилтийн хэмжээ, цавуулагын тоо, чанарын үзүүлэлтээр талх, үндэсний гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хэрэглэнэ.</p> <p>Өнгө: Цагаан буюу шаравтар туяатай.</p> <p>Үнэр: Буудайн гурилын хэвийн үнэртэй, исгэлэн буюу хөгцний зэрэг гадны үнэргүй байна.</p> <p>Амт:Буудайн гурилын хэвийн амттай, исгэлэн гашуун, чихэрлэг амтгүй байна.</p> <p>Эрдэс хольц:Зажлахад элсэрхэг буюу хатуу зүйл ажлагдахгүй байна.</p>

3	Физик, химийн шинж чанар	Чийглэг 15-15,5% ихгүй, үнслэг 0,75-0,85%-с ихгүй, ширхэгжилт, үдэц 2-3%-с ихгүй, капрон шигшүүрийн дугаар 38, микрон 180, нойтон цавуулагийн хэмжээ 26-30%-с багагүй, цавуулагийнн чанар 20-100 нэгж, ИДК-1-ийн заалт, бүлгээр II доошгүй, хүчиллэг 400Н, тосны хүчлийн тоо 30мг/100г ихгүй, төмөрлөг хольц, 3мг/кг уналтын тоо 200-300 сек багагүй, 100г гурлын туршилтын хэвтэй талхны эдэлхүүн 500 см 3 байна.
4	Савалгаа /кг/	Гурлыг “Гурилын шуудай MNS 2515:1994 ”-ийн шаардлага хангасан шуудай, уутанд 25 кг, 50 кг хүртэл жинтэйгээр жижиглэн савалж, амсарыг битүүмжилсэн байна.
5	Сав баглаа, боодол	“Гурилын шуудай MNS 2515:1994 ” -ийн шаардлага хангасан шуудай байна. Савалсан гурилын жингийн хэлбэлзэл +/- 1,0%-иас ихгүй байна. Гурилын тухайн үеийн чийглэгийн хэмжээнээс хамааруулан чийглэгийн зөрүүгээр жингийн нэмэгдэл, хорогдлыг тооцно.
6	Шошго, хаяглалт	Савалсан гурилын шуудай, уут бүр нь “Савалсан хүнсний бүтээгдэхүүний шошголтонд тавих ерөнхий шаардлага” MNS CAC 1:2007 стандартын шаардлагыг хангасан дараах агуулга бүхий хаяг, шошигтой байна. Үүнд: -Барааны тэмдэг ба үйлдвэрлэгчийн нэр хаяг. -Бүтээгдэхүүний нэр, ангилал. -Бүтээгдэхүүнтий цэвэр жин. - Үйлдвэрлэсэн он, сар өдөр. -Найрлага, илчлэг чанар. -Хадгалах хугацаа. -Стандартын дугаар, тэмдэглэгээ
7	Дүгнэлт шалгалт	Буудайн гурилын чанар, аюулгүй нь “Буудайн гурил. Техникийн ерөнхий шаардлага. MNS 0244:2009 ” стандартын шаардлага хангасан тухай улсын байцаагчийн дүгнэлттэй байх.
8	Хадгалалт, тээвэрлэлт	-Буудайн гурилыг агаарын солилцоо сайтай, 150С-с дээшгүй температуртай, 60%-с дээшгүй агаарын харьцангуй чийглэгтэй, хортон шавьжаар бохирдоогүй, гадны элдэв өвөрмөц үнэргүй, шороо чийгээс хамгаалсан агуулахад зориулалтын тавиур дээр эгнүүлэн хурааж эсвэл бункерт задгайгаар хадгалсан байх.

		<p>-Гурилыг үйлдвэрлэсэн өдрөөс хойш нэг жилээс доошгүй хугацаагаар хадгална.</p> <p>-Буудайн гурилыг зөөх тээврийн хэрэгсэл нь цэвэр, хуурай, гадны үнэргүй, хортон шавьжаар бохирдоогүй, шороо, чийгээс хамгаалсан бүрхүүлтэй байна.</p> <p>-Гүйцэтгэлийн хуваарьт заасан байршилд тухай бүрт нь тогтоосон хэмжээгээр хүргэнэ.</p>
--	--	--

Барааны нэр: Цагаан будаа

1	Стандарт	Цагаан будаа. Теникийн шаардлага: MNS ISO 7301:2000 стандарт
2	Барааны ерөнхий шинж чанар	<p>Өнгө: Цайвар шаргал өнгөтэй, ширхэгтэй.</p> <p>Амт: Хээгүй, механик хольцгүй, гаж буруу гадны нөлөөний амигүй байна.</p> <p>Чанар: Эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан, шороогүй.</p>
3	Савалгаа /кг/	Цагаан будааг стандартын шаардлага хангасан уут, шуудайнд савлаж, амсарыг битүүмжилсэн байх. /25-50 кг хүртэл хэмжээгээр савалсан байна.
4	Сав баглаа боодол	Бүтээгдэхүүний сав баглаа боодол нь эрүүл ахуйн шаардлага хангасан, бүтээгдэхүүнийг гэмтээх гадны нэг бодис агуулаагүй, гадны үнэр, амтыг нэвтрүүлэхгүй байх. Хэрэв шуудайнд савалсан бол уг шуудай нь бат, бөх, цэвэр байх.
5	Шошго, хаяглалт	<p>Савалсан цагаан будааны уут, шуудай бүр нь “Савалсан хүнсний бүтээгдэхүүний шошиголтонд тавих ерөгхий шаардлага” MNS CAC 1:2007 стандартыг хангасан дараах агуулга бүхий хаяг, шошигтой байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Үйлдвэрлэгчийн нэр хаяг, ялгах тэмдэг. -Бүтээгдэхүүний нэр, зэрэг, дугаар. -Бүтээгдэхүүний цэвэр, жин, кг. -Үйлдвэрлэсэн он, сар, өдөр. -Хадгалах хугацаа. -Хадгалах нөхцөл. -Стандартын дугаар.
6	Хадгалалт, тээвэрлэлт	<p>-Цагаан будааг зөөх тээврийн хэрэгсэл нь цэвэр, хуурай, гадны үнэргүй, хортон шавьжаар бохирдоогүй, ариун цэврийн шаардлага хангасан байна.</p> <p>-Цагаан будааг хуурай, цэвэр, хортон шавьжаар бохирдоогүй, агааржуулалт сайтай, ариун</p>

		<p>цэврийн шаардлага хангасан агуулахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сараас дээшгүй хугацаагаар хадгална.</p> <p>-Гүйцэтгэлийн хуваарьт заасан байршилд тухай бүрт нь тогтоосон хэмжээгээр хуваарийн дагуу хүргэнэ.</p>
--	--	--

Барааны нэр: Бусад хүнсний бүтээгдэхүүн

№	Багцын нэр, бүтээгдэхүүний нэр	Техникийн тодорхойлолт
1	Хуурай сүү	MNS (ISO) 1572:2000 , стандартыг хангасан байна. 1 ширхэг цай 1кг-р савлагдсан байна. Нийлүүлэх бүтээгдэхүүний дээжийг ирүүлнэ үү.
2	Исгэгч	Хөөлгөгч MNS (CAC) 4293:1995 стандартыг хангасан байна. Шаргал туяатай, сааралдуу өнгөтэй, бараан толбгүй, хөгц ба гадны ямар нэгэн үнэргүй, гадны ямар нэгэн амтгүй, задалхад нунтаг байдалтай. 1 ширхэг хөөлгөгч нь 500 гр савалгаатай байх.
3	Бусад амтлагч	Хоол амтлагч нь MNS 5519:2005 стандартыг баримтлана. Хоол амтлагч нь тус бүрдээ савалгаатай, үйлдвэрлэгчийн зөвшөөрөл, шинжилгээний бичиг, сав баглаа боодлын стандартын шаардлага хангасан, хадгалах горим алдагдаагүй байх. Нийлүүлэх бүтээгдэхүүний дээжийг ирүүлнэ.
4	Хуурай сүү	MNS 0219:2011 стандарт нийцсэн байна. Хуурай сүү: Шаргал туяатай, цагаан өнгөтэй, бараан толбогүй, хөгц ба гадны ямар нэгэн үнэргүй, гадны ямар нэгэн амтгүй, задалхад нунтаг байдалгүй, тослог 32%-с багагүй байна. Гадаад байдал: Битүүмжилсэн, бохирдолгүй, хортон шавьжийн сэг, зэм зэргийг хамарсан амьтны гаралтай хольцгүй байна. Эрүүл ахуй: Эрүүл мэндэд аюул учруулах бичил биетэн агуулаагүй байна. Эмгэг төрөгч агуулаагүй байх. Савлалт, хаяглалт: 5.1-5.5 дугаар зүйлд заасантай тохирч байна. 1 ширхэг хуурай сүү нь 1 кг-р савлагдсан.
5	Давс	MNS 5046:2001, MNS CAC 15052007 стандартын хангасан байна. Өнгө: Цагаан өнгөтэй, жижиг ширхэгтэй.

	<p>Амт: Гашуун амттай, механик хольцгүй, гаж буруу гадны нөлөөний амтгүй байна.</p> <p>Чанар: Эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан байна.</p> <p>Битүүмжлэл: Зориулалтын сав баглаа боодолтой, гадны гэмтэл, нөлөөнөөс хамгаалсан байна.</p> <p>Шошго хаяглалт: Савалсан давсны уут, шуудай бүр нь савалсан хүнсний бүтээгдэхүүний шошголтонд тавих ерөнхий шаардлага MNS CAC 150:2007 стандартын шаардлагыг хангасан дараах агуулга бүхий хаяг шошготой байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Үйлдвэрлэгчийн нэр хаяг, ялгах тэмдэг. -Бүтээгдэхүүний нэр, зэрэг, дугаар. -Бүтээгдэхүүний цэвэр, жин, кг -Үйлдвэрлэсэн он, сар, өдөр. -Хадгалах хугацаа. -Хадгалах нөхцөл. -Стандартын дугаар, тэмдэглэгээ <p>Хадгалалт тээвэрлэлт: Давс зөөх тээврийн хэрэгсэл нь цэвэр, хуурай, гадны үнэргүй, хортон шавьжаар бохирдоогүй, ариун уэврийн шаардлага бүрэн хангасан байна. 1 ширхэг нь 1 кг-р савлагдсан байна.</p> <p>Давсыг хуурай цэвэр, хортон шавьжаар борирдоогүй, агааржуулалт сайтай, ариун цэврийн шаардлага хангасан агуулахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сараас дээшгүй хугацаагаар хадгална.</p>
--	--

[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн техникийн тодорхойлолтын жишиг нөхцөл, стандарт, загварыг баримтлан техникийн тодорхойлолтыг боловсруулна.]